



Funded by
the European Union



Akademie



MEDIA
COUNCIL OF
MONGOLIA



VOICES
FOR
CHANGE

Европын Холбооны санхүүжилттэй Монголын төслийн хөндлөнгийн эцсийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний

СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

“Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төсөл

Албан тушаал:	Хөндлөнгийн үнэлгээ хийх зөвлөх
Гэрээний төрөл:	Богино хугацааны зөвлөх үйлчилгээ
Төсөл :	<i>“Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төсл</i>
Байршил :	Монгол
Ажил гүйцэтгэх хугацаа:	2026 оны 3-р улирал; үнэлгээний үйл ажиллагаа 10 ,11-р сард, эцсийн тайлан болон танилцуулга 12-р сард болно
Хэлний шаардлага:	Англи болон монгол хэл
Өргөдөл гаргах эцсийн хугацаа:	2026 оны 9-р сарын 21

I. Ерөнхий мэдээлэл

DW Akademie бол Deutsche Welle-н олон улсын хэвлэл мэдээллийн хөгжил, сэтгүүлзүйн сургалт, мэдлэг дамжуулах төв. Манай төслүүд нь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэлд саадгүй нэвтрэх эрхийг бэхжүүлдэг. DW Akademie нь дэлхий даяар хүмүүст найдвартай баримт, бүтээлч яриа хэлэлцээнд үндэслэн бие даан шийдвэр гаргах боломжийг олгодог. DW Akademie нь ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (BMZ) стратегийн түнш юм. Мөн ХБНГУ-ын Гадаад хэргийн яам болон Европын Холбооноос (EX) санхүүжилт авдаг бөгөөд 70 орчим оронд үйл ажиллагаа явуулдаг.

Европын Холбооны санхүүжилттэй “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг DW Akademie-н урт хугацааны түнш Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл (MCM)-тэй хамтран хэрэгжүүлж байна. Уг төсөл нь салбарын бие даасан байдал, сайн засаглал, нийгмийн эв нэгдлийг хангахад хувь нэмэр оруулах чадавхийг бэхжүүлэх замаар Монголын иргэний нийгэмд хариуцлагатай байдлыг бэхжүүлэх зорилготой юм. Энэ нь Монголын иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийн салбарт тулгарч буй ил тод, хариуцлагатай байдлын хангалтгүй байдал, олон нийттэй харилцах чадавх сул, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл болон улс төрийн оролцогчдын хоорондын итгэлцэл бага, түүнчлэн залуучууд болон эмзэг, гадуурхагдсан бүлгүүд бодлогын хэлэлцүүлэгт бодитой оролцох боломж хязгаарлагдмал зэрэг гол сорилтыг шийдвэрлэхэд чиглэнэ.

Төсөл нь иргэний нийгмийн байгууллагууд (ялангуяа тууштай оролцож буй 30 ИНБ-аас бүрдсэн үндсэн бүлэг), хэвлэл мэдээллийн салбарын оролцогчид болон сургагч багш нартай хамтран ажиллаж, залуучууд болон бусад эмзэг бүлгийг нөлөөллийн үйл ажиллагаа, олон нийтийн хэлэлцүүлэгт идэвхтэй татан оролцуулах цахим харилцааны

шинэ хэлбэрүүдийг хөгжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. ИНБ-ууд, хэвлэл мэдээлэл болон бусад оролцогч талуудын цахим харилцаа, олон нийтэд хүрч ажиллах үйл ажиллагаа, хамтын ажиллагааг бэхжүүлснээр төсөл нь Монгол Улсад илүү ил тод, хүртээмжтэй, оролцоонд суурилсан иргэний орон зайг дэмжих зорилготой юм.

Төсөл дуусах хугацаа ойртож буйтай холбогдуулан DW Akademie төслийн гүйцэтгэл болон хөгжлийн үр нөлөөг үнэлэх туршлагатай хөндлөнгийн үнэлгээ хийх зөвлөх хайж байна.

II. Үнэлгээний зорилго ба шалгуур

Үнэлгээ нь Европын Холбооны шаардлага бөгөөд хариуцлагыг хангах нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Үнэлгээний үндсэн зорилго нь байгууллагын түвшинд суралцах, туршлага хуримтлуулах явдал юм. Үнэлгээний үр дүнг DW Akademie, Хэвлэл мэдээллийн зөвлөл (ХМЗ) болон Европын Холбооны цаашдын төсөл, техникийн арга барилыг боловсруулахад ашиглана.

Үнэлгээ нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) Хөгжлийн тусламжийн хорооноос (DAC) тодорхойлсон үнэлгээний дараах дөрвөн шалгуурт төвлөрнө:

- **Үр нөлөөтэй байдал (Effectiveness):** Төсөл логик хүрээнд тодорхойлсон зорилго болон төлөвлөсөн үр дүндээ хэр зэрэг хүрсэн бэ? Нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбогдуулан төслийн логикт ямар нэгэн өөрчлөлт, зохицуулалт хийсэн үү?
- **Үр ашигтай байдал (Efficiency):** Төслийн үр дүнг батлагдсан төсөв болон хугацааны хүрээнд бий болгож чадсан уу? Удирдлагын дэмжлэг хэр үр ашигтай байсан бэ? Хэрэгжүүлсэн арга хэрэгслүүдийг хэр үр ашигтай ашигласан бэ?
- **Нөлөөлөл (Impact):** Төсөл нь хөгжлийн илүү өндөр түвшний үр нөлөөнд (жишээлбэл, бүтцийн өөрчлөлт, үр шим хүртэгчдийн хандлага эсвэл чадавхад гарсан өөрчлөлт гэх мэт) хувь нэмэр оруулсныг нотлох ямар баримт байна вэ? Урьдчилан төлөвлөөгүй эерэг эсвэл сөрөг үр нөлөө гарсан уу?
- **Тогтвортой байдал (Sustainability):** Хөгжлийн хүрсэн үр дүн цаашид хадгалагдан үлдэх магадлал хэр өндөр вэ?

III. Ажлын цар хүрээ

Үнэлгээ хийх зөвлөх нь дараах ажлуудыг хариуцан гүйцэтгэнэ:

1. Төслийн холбогдох баримт бичгүүдийг (төслийн санал, шалгуур үзүүлэлт бүхий логик хүрээ, тайлан зэрэг) хянаж, төслийн зорилгод нийцсэн үнэлгээний хүрээ боловсруулах.
2. Арга зүй, мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл болон хугацааны хуваарийг тусгасан ажлын төлөвлөгөө боловсруулах.



Funded by
the European Union



Akademie



MEDIA
COUNCIL OF
MONGOLIA



VOICES
FOR
CHANGE

3. Мэдээлэлд суурилсан зөвшөөрөл авах, нууцлалыг хангах зэрэг ёс зүйн хэм хэмжээг баримтлан мэдээлэл цуглуулах тохиромжтой аргуудыг (ярилцлага, санал асуулга зэрэг) боловсруулж, хэрэгжүүлэх.
4. Чанарын болон тоон мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх.
5. Дээр дурдсан OECD DAC-ийн үнэлгээний дөрвөн шалгуурын дагуу төслийн гүйцэтгэлийг үнэлэх.
6. Үнэлгээний үр дүн, дүгнэлт болон төслийн үргэлжлэл эсвэл ирээдүйд хэрэгжүүлэх ижил төстэй төслүүдэд зориулсан хэрэгжүүлэх боломжтой зөвлөмжийг багтаасан үнэлгээний эцсийн тайлан бэлтгэх (баримт бичгийг монгол, англи хэлээр бэлтгэнэ).
7. Гол үр дүн болон зөвлөмжийг төслийн багт танилцуулах.

Үнэлгээ хийх зөвлөх дээр дурдсан ажлуудыг гүйцэтгэхэд ойролцоогоор **ажлын 20 хоног** хуваарилна. Ирүүлэх ажлын төлөвлөгөөнд эдгээр ажлыг өгөгдсөн хугацаанд хэрхэн гүйцэтгэхийг нарийвчлан тусгаж, бүх үр дүнгийн бүтээгдэхүүнийг харилцан тохиролцсон хугацаанд багтаан хүлээлгэн өгөх нөхцөлийг хангана.

Төслийн дотоод мониторингийн бүх мэдээлэл болон холбогдох төслийн баримт бичигтэй танилцах боломжтой байна. Гэрээт тал энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан, үүнд DW болон гуравдагч талуудын үйл ажиллагаатай холбоотой гэрээ, баримт бичиг, бичвэр, тэмдэглэл, цахим бүртгэл, аман харилцаа зэрэг мэдээллийг багтаах боловч үүгээр хязгаарлагдахгүй аливаа мэдээллийг ерөнхий зориулалтын хиймэл оюун ухаан ашиглан боловсруулахыг хориглоно. Түүнчлэн DW эсвэл холбогдох гуравдагч талын эх мэдээлэлтэй буцаан холбож тогтоох боломжтой бол ийм мэдээллийг нэгтгэсэн эсвэл нэргүйжүүлсэн хэлбэрээр хиймэл оюун ухаан ашиглан боловсруулахад мөн энэхүү хориг хамаарна.

IV. Тавигдах шаардлага, туршлага

- Хөгжлийн хамтын ажиллагааны төслүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (M&E) хийж байсан нотлогдсон туршлагатай байх.
- Чанарын болон тоон мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх чиглэлээр мэргэшсэн байх.
- Дүн шинжилгээ хийх болон баримт бичиг боловсруулах өндөр ур чадвартай байх.
- Монгол, англи хэлийг чөлөөтэй эзэмшсэн байх.
- Хэвлэл мэдээллийн хөгжлийн чиглэлээр мэдлэг, туршлагатай бол давуу тал болно.
- Европын Холбооны санхүүжилттэй төслүүдэд үнэлгээ хийж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Зүүн Азийн орнууд эсвэл ижил төстэй нөхцөлд үнэлгээ хийж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Зохион байгуулах, харилцах болон чиглүүлэн хөтлөх өндөр ур чадвартай байх.
- Соёл хоорондын харилцааны ур чадвартай, олон янзын орчин нөхцөлд ажиллаж байсан туршлагатай байх.

V. Ажлын зохион байгуулалт болон хүлээлгэн өгөх үр дүн

Ажлын зохион байгуулалт:



Funded by
the European Union



Akademie



MEDIA
COUNCIL OF
MONGOLIA



VOICES
FOR
CHANGE

- Ойролцоогоор ажлын 20 хоног ажиллана. Орон нутгийн жишиг тарифт үндэслэн өдрийн ажлын хөлсний саналаа ирүүлнэ үү.
- Зөвлөх нь DW Akademie болон Хэвлэл мэдээллийн зөвлөлийн (ХМЗ) төслийн ажилтнуудтай тогтмол хамтран ажиллана.
- Бүх харилцааг DW Akademie-тай англи хэлээр, ХМЗ-тэй монгол хэлээр явуулна.

Зөвлөх нь дараах үр дүнгийн бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгөх үүрэгтэй:

- Үнэлгээний хүрээ, арга зүй, мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл болон хугацааны төлөвлөгөөг тусгасан товч эхлэлийн тайлан (inception report).
- Үнэлгээний дөрвөн шалгуурын дагуу нотлох баримтад үндэслэсэн урьдчилсан үр дүн, дүгнэлт, түүнчлэн төслийн боломжит үргэлжлэл болон ирээдүйд хэрэгжүүлэх ижил төстэй төслүүдэд зориулсан тодорхой, хэрэгжүүлэх боломжтой зөвлөмжийг багтаасан үнэлгээний тайлангийн төсөл.
- Үнэлгээний гол үр дүн, зөвлөмжийг төслийн багтай хийх онлайн дүгнэлт, хэлэлцүүлгийн уулзалтаар танилцуулах.
- Төслийн багийн санал хүсэлтийг тусгасан бөгөөд хураангуй болон холбогдох бүх хавсралтыг багтаасан үнэлгээний эцсийн тайлан.

VI. Хэрхэн өргөдөл гаргах вэ?:

Сонирхсон өргөдөл гаргагчид дараах материалыг багтаасан саналаа ирүүлнэ:

- Өргөдөл гаргагчийн ашиглах арга зүй болон үнэлгээний арга барилыг тодорхой тусгасан санал болон ажлын төлөвлөгөөний төсөл.
- Төсөлд үнэлгээ хийж байсан холбогдох туршлагын тодорхойлолт, үүнд ажиллах хүсэл, сонирхлоо илэрхийлсэн товч тайлбар багтана.
- Товч намтар (CV).
- Еврогоор илэрхийлсэн өдрийн ажлын хөлсний тариф.
- Англи хэлээр бэлтгэсэн материалыг нэг PDF файл болгон **dw-akademie.mongolia@dw.com** цахим шуудангийн хаягаар ирүүлнэ.
- Материал хүлээн авах эцсийн хугацаа: 2026 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 23:00 цаг (Улаанбаатарын цагаар).

VII. Төлбөрийн нөхцөл

Хүлээгдэж буй бүх ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэсний хариуд DW Akademie нь үнэлгээчид тохиролцсон хэмжээний төлбөрийг еврогоор (EUR) дараах нөхцөлөөр төлнө:

- Deutsche Welle нь бүх үр дүнгийн бүтээгдэхүүнийг бүрэн хүлээлгэн өгч, эцсийн дэлгэрэнгүй нэхэмжлэхийг ирүүлсний дараа төлбөрийг хийнэ.
- Еврогоор мөнгөн шилжүүлэг хүлээн авах боломжтой банкны данстай байна.